**АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ЦЭВЭЭНЖАВ ТАНАА**

# АКПАР АУДИТ ХХК

Огноо 2013.02.06

Дугаар 210

## ЗӨРЧИЛГҮЙ АУДИТЫН ТАЙЛАН

Бид "Албан журмын даатгагчдын холбоо" ТББ-ын 2012 оны 12 дугаар сарын 31-ний эцэг өдрөөр дуусгавар болсон Үлдэгдэл баланс, Үр дүнгийн тайлан, Цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан болон Мөнгөн гүйлгээний тайлан нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд ба бусад тайлбар тодруулгаас бүрдсэн 2012 оны жилийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

### Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлантаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу бэлтгэж үнэн зөв танилцуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогоо сонгож, түүнийгээ тайлант жилийн туршид тогтвортой мөрдөх, бүртгэлээ хуулийн дагуу зохион байгуулах нь байгууллагын удирдлагын үүрэг хариуцлага болно.

Мөн түүнчлэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хөрөнгийн янз бүрийн залилт ажиллагаанд өртүүлэхгүй байхаар дотоод хяналтын системийг бий болгох, хэрэгжүүлэх нь удирдлагын хариуцлага юм.

### Аудиторын хүлээх хариуцлага

Бид гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангууд Нягтлан бодох бүртгэлийн хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу, үнэн зөв шударгаар илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт гаргах үүрэгтэй.

Бид аудитаа Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбооноос гаргасан Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр Стандарт нь санхүүгийн тайлангуудад материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажил нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын үндэслэлийн тестийн үндсэн дээр шалгаж батлах ажлыг багтаадаг. Санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналттай байж болох эрсдэлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээг хийхэд байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш бөгөөд тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв танилцуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг.

Ажлын 1-р байр: Баянзүрх дүүрэг, 1-р хороо Монголын ХАА-н Хоршоологчдын үндэсний холбооны байр 209,210 тоот
Утас/Факс: 976-11-462131, 976-91919758
Ажлын 2-р байр: Баянгол дүүрэг, 6-р хороо Кёкүпю цамхаг, 7 давхар, 706 тоот. Утас: 976-50884272, 976-99121599
И-мэйл: akpar.audit@gmail.com

Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайлант бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцоолол, хэрэглэсэн бүртгэлийн зарчмуудыг шалгах ажлыг өөртөө агуулдаг.

Бидний хийсэн аудитын ажил нь энгээр санхүүгийн тайланд дүгнэлт гаргах хангалттай үндэслэл болж чадна гэж үзлээ.

**Аудитын санал дүгнэлт**

Бидний дүгнэлтээр "Албан журмын даатгагчдын холбоо" ТББ-ын 2012 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн тайланд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль түүнд нийцүүлэн мөрдөж байгаа холбогдох заавар, журмыг материаллаг түвшингийн хэмжээнд зөрчсөн гэж үзэх ямар нэгэн зүйл ажиглагдаагүй болно.

"Акпар-Аудит" компанийн
ерөнхий захирал Х.Баянбай

**“АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО”**

**ҮЛДЭГДЭЛ ТЭНЦЭЛ**

**2012 оны 12-р сарын 31-нээр**

(Төгрөгөөр)

| **Балансын зүйл** | **Үлдэгдэл** | |
|---|---|---|
| | Эхний | Эцсийн |
| ***ХӨРӨНГӨ*** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 83 961 034,61 | 99 479 191,20 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | | |
| Үнэлгээний хасагдуулга | | |
| Дансны авлага | | |
| Найдваргүй авлагын хасагдуулга | | |
| Бусад авлага | 320 960,00 | 12 000 000,00 |
| Бараа материал | 798 540,00 | 5 386 808,00 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 1 500 000,00 | 13 944 000,00 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **86 580 534,61** | **130 809 999,20** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | | |
| Хуримтлагдсан элэгдэл | | |
| Бусад үндсэн хөрөнгө | 9 288 000,00 | 50 354 082,00 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (4 488 591,00) |
| Дуусаагүй барилга | | |
| Мал амьтад (ХАА-н үйлдвэрлэлийн) | | |
| Биет бус хөрөнгө | | |
| Хуримтлагдсан элэгдэл | | |
| Үндсэн хөрөнгө | | |
| Үнэлгээний хасагдуулга | | |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **9 288 000,00** | **45 865 491,00** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **95 868 534,61** | **176 675 490,20** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | | |
| **Өр төлбөр** | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | |
| Дансны өглөг | | |
| Цалингийн өглөг | | |
| Орлогын татварын өглөг | | |
| ХАОТ-ын өглөг | 20 000,00 | |
| НӨАТ-ын өглөг | | |
| Бусад татварын өглөг | | 896 087,50 |
| ЭМНД-ийн шимтгэлийн өглөг | | |
| Ноогдол ашгийн өглөг | | |
| Банкны богино хугацаат зээл | | |
| Бусад өглөг | | |
| Урьдчилж орсон орлого | | |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **20 000,00** | **896 087,50** |

| | | |
|---|---|---|
| **Урт хугацаат өр төлбөр** | | |
| Урт хугацаат векселийн өглөг | | |
| Урт хугацаат зээл | | |
| Урт хугацаат бондын өглөг | | |
| Бусад урт хугацаат өглөг | | |
| Нөөцийн сан | | 10 000 000,00 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **0,00** | **10 000 000,00** |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **20 000,00** | **10 896 087,50** |
| **Эзэмшигчдийн өмч** | | |
| Нөөц: а) хязгаарлалтгүй | | |
| б) хязгаарлалттай | 9 288 000,00 | |
| Дахин үнэлгээний нөөц | | |
| Цэвэр хөрөнгийн бусад хэсэг | | |
| **Хуримтлагдсан үр дүн, (алдагдал)** | **86 560 534,61** | **165 779 402,70** |
| Тайлант үеийн үр дүн | 93 249 134,61 | 69 930 868,09 |
| Өмнөх үеийн үр дүн | (6 688 600,00) | 95 848 534,61 |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **95 848 534,61** | **165 779 402,70** |
| Үүнээс: Цөөнхийн хувь оролцоо | | |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **95 868 534,61** | **176 675 490,20** |

## ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

**2012 оны 12-р сарын 31-нээр**

(Төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант оны дүн |
|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 126 837 868,61 | 340 000 000,00 |
| **Борлуулалтын орлогын дүн** | **126 837 868,61** | **340 000 000,00** |
| Зохион байгуулах арга хэмжээний зардал | | |
| Ерөнхий удирдлагны зардал | 33 588 734,00 | 302 797 477,12 |
| **Үйл ажиллагааны зардлын дүн** | **33 588 734,00** | **302 797 477,12** |
| Үндсэн үйл ажиллагааны үр дүн | | 42 728 345,21 |
| Үндсэн бус үйл ажиллагааны алдагдал | | 10 000 000,00 |
| **Тайлант үеийн цэвэр үр дүн (алдагдал)** | **93 249 134,61** | **69 930 868,09** |